ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/81/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 70483413<br>Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055<br>Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор Д.Цэрэнханд<br>Утас: 99147999<br>Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9

3. Аудитын тайлан ..... 10

3.1 Ерөнхий зүйл ..... 10

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 11

3.4 Материаллаг байдал ..... 11

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 12

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 12

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 13

3.8 Аудитын гол асуудал ..... 13

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 13

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 13

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 13

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 14

4. Аудитын илрүүлэлт ..... 14

4.1 Залруулсан алдаа ..... 14

4.2 Төлбөрийн акт ..... 14

4.3 Албан шаардлага ..... 14

4.4 Зөвлөмж ..... 15

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 16

танай ____________ -ны № ____________ -т

АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.НАЯНБУУ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07...64

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **260,396,869.35** | **177,744,206.54** |
| **33** | **АВЛАГА** | **42,366,981.00** | **9,866,981.00** |
| **33500** | **Бусад авлага** | **42,366,981.00** | **9,866,981.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 32,500,000.00 | 0.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 9,866,981.00 | 9,866,981.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **218,029,888.35** | **160,677,225.54** |
| **35100** | **Түүхий эд материал** | **153,965,494.82** | **110,924,225.54** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 54,168,448.00 | 31,777,843.00 |
| 35130 | Эм боох материал | 99,797,046.82 | 79,146,382.54 |
| **35400** | **Хангамжийн материал** | **64,064,393.53** | **49,753,000.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,271,919.00 | 485,420.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,647,784.53 | 25,937,530.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,527,360.00 | 2,870,720.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 34,617,330.00 | 20,459,330.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **629,394,862.26** | **563,032,971.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **629,394,862.26** | **563,032,971.16** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **569,998,195.52** | **503,636,304.42** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 29,024,023.03 | 66,524,023.03 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -2,121,314.15 | -3,558,575.71 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 278,234,029.67 | 278,234,029.67 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -128,198,647.18 | -165,086,056.78 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 559,053,812.56 | 569,755,812.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -191,597,060.67 | -264,894,317.01 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,340,786.02 | 30,340,786.02 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -4,737,433.76 | -7,679,397.36 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **59,396,666.74** | **59,396,666.74** |
| 39301 | Программ хангамж | 1,980,000.00 | 1,980,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -403,333.26 | -403,333.26 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 57,820,000.00 | 57,820,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **889,791,731.61** | **740,777,177.70** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **889,791,731.61** | **740,777,177.70** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **889,791,731.61** | **740,777,177.70** |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **833,524,589.96** | **684,510,036.05** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 598,025,343.53 | 833,524,589.96 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 235,499,246.43 | -149,014,553.91 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 56,267,141.65 | 56,267,141.65 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **889,791,731.61** | **740,777,177.70** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,817,802,158.58** | **1,867,550,976.48** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **417,054,178.58** | **477,531,646.48** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **417,054,178.58** | **477,531,646.48** |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 212,253,436.15 | 477,531,646.48 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,400,747,980.00** | **1,390,019,330.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **733,876,200.00** | **864,858,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 733,876,200.00 | 864,858,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **666,871,780.00** | **525,160,430.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 487,642,300.00 | 487,510,330.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 179,079,480.00 | 37,650,100.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,582,302,912.15** | **2,016,565,530.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,582,302,912.15** | **2,016,565,530.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,527,419,560.04** | **1,889,692,490.41** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **135,379,319.00** | **498,672,327.00** |
| 210101 | Үндсэн цалин | 99,812,519.00 | 406,269,993.48 |
| 210102 | Нэмэгдэл | 32,006,800.00 | 75,258,333.52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,560,000.00 | 17,144,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,900,900.00** | **70,765,322.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,485,800.00 | 47,499,897.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,103,800.00 | 5,100,124.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 883,100.00 | 5,604,473.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 220,700.00 | 1,069,693.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,207,500.00 | 11,491,135.12 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **16,137,065.00** | **19,879,034.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,876,075.00 | 2,347,416.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,875,036.00 | 17,141,582.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 385,954.00 | 390,036.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **81,144,024.57** | **52,932,376.10** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,412,100.00 | 9,921,629.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,468,960.00 | 14,312,670.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,426,274.00 | 6,350,859.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 932,000.00 | 1,252,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 48,904,690.57 | 21,094,718.10 |
| **2105** | **Нормативт зардал** | **256,500,894.26** | **605,251,838.09** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 256,500,894.26 | 605,251,838.09 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **0.00** | **2,308,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 2,308,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **941,218,024.14** | **478,713,750.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 939,949,244.14 | 474,241,650.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 286,680.00 | 290,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 272,100.00 | 272,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 3,800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **78,987,443.07** | **161,169,843.10** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,672,240.00 | 46,605,952.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 72,315,203.07 | 114,563,891.10 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **54,883,352.11** | **126,873,039.98** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **46,497,793.00** | **16,840,600.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 45,097,793.00 | 16,250,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,400,000.00 | 590,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **8,385,559.11** | **110,032,439.98** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,374,941.86 | 110,032,439.98 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **235,499,246.43** | **-149,014,553.91** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **235,499,246.43** | **-149,014,553.91** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **56,267,141.65** | **598,025,343.53** | **654,292,485.18** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **56,267,141.65** | **598,025,343.53** | **654,292,485.18** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **6** | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **7** | **Өмчид гарсан өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **8** | **Зарласан ногдол ашиг** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **235,499,246.43** | **235,499,246.43** |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **56,267,141.65** | **833,524,589.96** | **889,791,731.61** |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **56,267,141.65** | **833,524,589.96** | **889,791,731.61** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **56,267,141.65** | **833,524,589.96** | **889,791,731.61** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -149,014,553.91 | -149,014,553.91 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **56,267,141.65** | **684,510,036.05** | **740,777,177.70** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,401,747,980.00** | **1,390,019,330.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,000,000.00** | **0.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,000,000.00** | **0.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,000,000.00** | **0.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,400,747,980.00** | **1,390,019,330.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **733,876,200.00** | **864,858,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 733,876,200.00 | 864,858,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **666,871,780.00** | **525,160,430.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 487,642,300.00 | 487,510,330.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 179,079,480.00 | 37,650,100.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 150,000.00 | 0.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,394,647,980.00** | **1,359,317,330.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,394,647,980.00** | **1,359,317,330.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,339,764,627.89** | **1,232,444,290.02** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **145,076,200.00** | **498,672,327.00** |
| 210101 | Үндсэн цалин | 109,509,400.00 | 406,269,993.48 |
| 210102 | Нэмэгдэл | 32,006,800.00 | 75,258,333.52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,560,000.00 | 17,144,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,900,900.00** | **70,765,322.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,485,800.00 | 47,499,897.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,103,800.00 | 5,100,124.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 883,100.00 | 5,604,473.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 220,700.00 | 1,069,693.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,207,500.00 | 11,491,135.12 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **16,137,065.00** | **19,879,034.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,876,075.00 | 2,347,416.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,875,036.00 | 17,141,582.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 385,954.00 | 390,036.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **30,659,464.00** | **29,063,949.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,107,820.00 | 6,338,630.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,464,670.00 | 15,291,460.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,426,274.00 | 6,350,859.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 660,700.00 | 1,083,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **60,835,300.00** | **93,019,374.90** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 60,585,300.00 | 92,814,174.90 |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 250,000.00 | 205,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,812,390.00** | **100,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,462,390.00 | 100,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,350,000.00 | 0.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **0.00** | **2,308,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 2,308,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,063,449,668.89** | **518,455,483.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,062,180,888.89 | 506,783,383.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 286,680.00 | 290,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 272,100.00 | 272,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 11,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **893,640.00** | **180,800.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 893,640.00 | 180,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **54,883,352.11** | **126,873,039.98** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **46,497,793.00** | **16,840,600.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 45,097,793.00 | 16,250,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,400,000.00 | 590,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **8,385,559.11** | **110,032,439.98** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,374,941.86 | 110,032,439.98 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 10,617.25 | 0.00 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **7,100,000.00** | **30,702,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,100,000.00** | **30,702,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **7,100,000.00** | **30,702,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,100,000.00 | 30,702,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-7,100,000.00** | **-30,702,000.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **864,858,900.00** | **754,827,932.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **864,858,900.00** | **754,827,932.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **848,017,900.00** | **737,987,332.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **597,588,000.00** | **498,672,327.00** |
| 210101 | Үндсэн цалин | 474,381,200.00 | 406,269,993.48 |
| 210102 | Нэмэгдэл | 105,222,800.00 | 75,258,333.52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,984,000.00 | 17,144,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **79,630,900.00** | **70,765,322.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,934,000.00 | 47,499,897.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,069,900.00 | 5,100,124.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,356,600.00 | 5,604,473.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,214,000.00 | 1,069,693.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,056,400.00 | 11,491,135.12 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **19,959,700.00** | **19,879,034.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,427,100.00 | 2,347,416.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,141,600.00 | 17,141,582.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 391,000.00 | 390,036.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **26,406,200.00** | **24,737,549.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,339,000.00 | 6,338,630.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,965,100.00 | 10,965,060.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,019,100.00 | 6,350,859.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,083,000.00 | 1,083,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,749,100.00** | **2,749,100.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,543,900.00 | 2,543,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 205,200.00 | 205,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,373,000.00** | **3,373,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,373,000.00 | 3,373,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,308,000.00** | **2,308,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,308,000.00 | 2,308,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **115,822,200.00** | **115,322,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 103,650,100.00 | 103,650,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 290,000.00 | 290,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 272,100.00 | 272,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 11,000,000.00 | 11,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **180,800.00** | **180,800.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 180,800.00 | 180,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **16,841,000.00** | **16,840,600.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **16,841,000.00** | **16,840,600.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,250,600.00 | 16,250,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 590,400.00 | 590,000.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **864,858,900.00** | **754,827,932.12** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **864,858,900.00** | **754,827,932.12** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 864,858,900.00 | 754,827,932.12 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **525,158,957.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **525,158,957.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 525,158,957.90 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,326,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,326,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 90,270,274.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 90,270,274.90 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 430,562,283.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 430,562,283.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,472.10** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 1,472.10 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 525,160,430.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 525,160,430.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 487,510,330.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,650,100.00 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бужинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/24 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, оношлох, тэмцэх,мал амьтны гаралтай бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг баталгаажуулах, мал эмнэлгийн байгууллага, нэгжийг нэгдсэн бодлогоор ханган нийтийн эрүүл мэндийг хамгаалахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу өөрчлөлт орлоо.
Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 1,582.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 31.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 25.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 2,016.5 сая төгрөгөөс 2 хувиар тооцоход 40.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 32.2 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50 хувиар буюу 169.8 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 160.7 сая төгрөг болж 57.3 сая төгрөгөөр буурсан нь бараа материал акталж устгасантай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 167.5 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 477.5 сая төгрөгийн бараа материал авч, үйл ажиллагаандаа 681.3 сая төгрөгийн материалыг зарцуулж, 21.0 сая төгрөгийн материалыг акталж устгажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,004.6 сая төгрөг болж 48.2 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 740.7 сая төгрөг болж 149.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 3 хувиар буюу 49.7 сая төгрөгөөр өссөн нь санхүүжилт өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 684.5 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 914.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 49.4 сая төгрөгөөр бууруулж, 864.8 сая төгрөгөөр баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 864.8 сая төгрөгийн төсөв баталснаас 864.8 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 864.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 754.8 сая төгрөгийг зарцуулж 110.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 754.8 сая төгрөг буюу 87 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 98.9 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 8.8 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1.6 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 487.5 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 37.6 сая төгрөг нийт 525.2 сая төгрөгийн орлого орсноос бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 430.5 сая төгрөгийг, эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад 90.3 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 4.3 сая төгрөгийг зарцуулжээ.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 1,802.1 сая төгрөгийн 72 мэдээллийг ил тод байршуулахаас 1,802.1 сая төгрөгийн 72 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 6.5 сая төгрөгийн худалдан авалтын И баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28.2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 72.1 сая төгрөгийн албан шаардлага, 17.1 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар бараа материалын тайлангийн тулгалт, эмийн тулгалт, авлагын барагдуулалт, Дата ланд ХХК руу урьдчилж шилжүүлсэн зардлыг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 29.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 29.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант онд санхүүгийн тайлангийн тайланд залруулга хийгдээгүй.

### 4.2 Төлбөрийн акт

Шатахууны зардлаас 0.3 сая төгрөгийг зориулалт бусаар гадны байгууллагад өгсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

Шуудан холбооны зардлаас 0.9 сая төгрөгийн интернэтийн төлбөрийн оны эцэст бөөн дүнгээр сумдын байцаагч нарт олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүллээ.

Хугацаа дууссан 17.4 сая төгрөгийн эмийг акталж устгасан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүллээ.

Тайлант онд 3.7 сая төгрөгийн худалдан авалтын И баримтыг дутуу шивүүлсэн нь Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, тоноглол, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүллээ.

Төсвийн төлөвлөлтийн программ худалдан авч, 2022 оны төлбөр 7.2 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүллээ

**4.4 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Мал эмнэлгийн газар | 5 | 29.9 | | | 1 | 0.3 | 4 | 32.0 | | |
| | Дүн | 5 | 29.9 | | | 1 | 0.3 | 4 | 32.0 | | |

# Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Мал эмнэлгийн газар    Аудитын код: ГАА-2022/81/-НА-СТА-ТШЗ

Байгууллагын нэр:МЭГ

| № | Нөлөөлж буй АГАДҮТ | АГАДҮТ-н дэд анги | Товч утга | Мөнгөн дүн | Шалгуур | | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | |
| 1 | Ажил гүйлгээний анги | Зардал | Шатахууны зардлаас 256.2 мянган төгрөгийг гадны байгууллагад зориулалт бусаар өгсөн. | 256.2 | УСНББОУС-1, 12, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах | Төлбөрийн акт | Хүлээн зөвшөөрсөн | | Төлбөрийн акт |
| 2 | Ажил гүйлгээний анги | Зардал | Хугацаа дууссан 17,406.3 мянган төгрөгийн эмийг акталж устгасан | 17,406.31 | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.3 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" | Албан шаардлага | Хүлээн зөвшөөрсөн | | Албан шаардлага |
| 3 | Ажил гүйлгээний анги | Зардал | Төсвийн төлөвлөлтийн программ худалдан авч, 2022 оны төлбөрийг урьдчилж шилжүүлсэн байна. | 7,200.0 | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.21 | Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" | Албан шаардлага | Хүлээн зөвшөөрсөн | | Албан шаардлага |
| 4 | Ажил гүйлгээний анги | Өглөг | Шуудан холбооны зардлаас 925.0 мянган төгрөгийн интернетийн төлбөрийн оны эцэст бөөн дүнгээр сумдын байцаагч нарт олгосон | 925.00 | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.21 | Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" | Албан шаардлага | Хүлээн зөвшөөрсөн | | Албан шаардлага |
| 5 | Ажил гүйлгээний анги | Мөнгөн хөрөнгө | Тайлант онд 3,771.8 мянган төгрөгийн худалдан авалтын И баримтыг дутуу шивүүлсэн байна | 3,771.90 | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.19 | Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, тоноглол, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." | Албан шаардлага | Хүлээн зөвшөөрсөн | | Албан шаардлага |
| | | | | 29,559.41 | - | - | - | - | - | - |

Бэлтгэсэн:
Ахлах Аудитор: Д.Цэрэнханд

Анхан шатанд хянасан:
Аудитын менежер: Д.Ордэнэчимэг

Хоёр дахь шатанд хянасан:
Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр

МЭГ
Дарга

Нягтлан бодогч

Танилцаж зөвшөөрсөн:

Д.Наянбуу

Д.Болормаа

## Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Мал эмнэлгийн газар    Аудитын код: ГАА-2022/81/-НА-СТА-ТШ3

Байгууллагын нэр:МЭГ

| № | Нөлөөлж буй АГАДУТ | АГАДУТ-н дэд анги | Товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур: Стандартын заалт | Шалгуур: Хууль тогтоомжийн заалт | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ажил гүйлгээний анги | Зардал | Шатахууны зардлаас 256.2 мянган төгрөгийг гадны байгууллагад зориулалт бусаар өгсөн. | 256.2 | 256.2 | 256.2 | УСНББОУС-1, 12, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах | Төлбөрийн акт | | | |
| 2 | Ажил гүйлгээний анги | Зардал | Хугацаа дууссан 17,406.3 мянган төгрөгийн эмийг акталж устгасан | 17,406.31 | 17,406.31 | 17,406.31 | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.3 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" | Албан шаардлага | | | |
| 3 | Ажил гүйлгээний анги | Зардал | Төсвийн төлөвлөлтийн программ худалдан авч, 2022 оны төлбөрийг урьдчилж шилжүүлсэн байна. | 7,200.0 | 7,200.0 | 7,200.0 | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.21 | Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" | Албан шаардлага | | | |
| 4 | Ажил гүйлгээний анги | Өглөг | Шуудан холбооны зардлаас 925.0 мянган төгрөгийн интернетийн төлбөрийн оны эцэст бөөн дүнгээр сумдын байцаагч нарт олгосон | 925.00 | 925.00 | 925.00 | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.21 | Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" | Албан шаардлага | | | |
| 5 | Ажил гүйлгээний анги | Мөнгөн хөрөнгө | Тайлант онд 3,771.8 мянган төгрөгийн худалдан авалтын И баримтыг дутуу шивүүлсэн байна | 3,771.90 | 3,771.90 | | УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.19 | Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, тоног төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." | Албан шаардлага | | | |
| | | | | 29,559.41 | 29,559.41 | 25,787.51 | - | - | - | - | - | - |

Бүртгэсэн:
Ахлах Аудитор: Д.Цэрэнханд 2022.02.14

Анхан шатанд хянасан:
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг 2022.02.14

Хоёр дахь шатанд хянасан:
Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр 2022.02.14

8217144139
ДЮА0060 0018301

Танилцаж зөвшөөрсөн:
МЭГ
Дарга Д.Наянбуу
Нягтлан бодогч Д.Болормаа